

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Нийгмийг өргөн утгаар нь авч үзсэн ойлголт аль нь вэ? /1 оноо/
  - A. Нийгэм бол амьд организм лугаа өөрөө хөгжигч тогтолцоо
  - B. Хамтын аж амьдрал, харилцаа бүхий бие биедээ харилцанүйлчлэл үзүүлэгч хүмүүсийн нэгдэл
  - C. Улс орон, ард түмний нийгэм, улстөр, эдийн засаг, соёлын бат тогтвортой, харилцаа холбоо бүхий хүмүүсийн зохионбайгуулалттай том нэгдэл
  - D. Нийгэм хүний амьдралын оршин тогтнох зайлшгүй орчин
  - E. Нийгэм бол хүмүүсийн гэрээ хэлцэл, хэм хэмжээ, хүсэл сонирхлын нэгдэл
2. Нийлмэл нийгмийн ялгагдах шинжид аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
  - A. Хүмүүсийн хоорондын олон янзын тогтвортой, өргөн холбоо харилцаа
  - B. Нийгмийн анги, давхрааны ялгарал/ удирдагч ба удирдуулагч хүмүүс/
  - C. Нийгмийг удирдах төр, засаг болон эрх мэдлийн ялгаа бий болсон
  - D. 50000-40000 жилийн өмнө үүссэн. 10000-6000 жилийн өмнө үүссэн
3. Дорж компанийн захирлын зөвлөлийн хуралд тодорхой санал оруулжээ. Энэтохиолдолд нийгмийн харилцааны ямар түвшин илэрч байгааг тэмдэглэнэ үү /2 оноо/
  - A. Бие хүмүүс хоорондын
  - B. Нийгмийн бүлэг хоорондын
  - C. Иргэн ба байгууллага хоорондын
  - D. Байгууллага хоорондын
  - E. Нийгэм хоорондын
4. Дараах бодомжуудын аль нь зөв бэ? /1 оноо/
  - A. Нийгэм бол хүмүүс, бүлгүүдийн харилцааны илэрхийлэл мөн
  - B. Нийгэм бол угсаатны харилцаа
  - C. Нийгэм бол хүмүүсийн бөөгнөрөл
  - D. Нийгэм бол олон улсын харилцаа
  - E. Нийгэм бол үнэт зүйл, үнэлэмжийн харилцаа
5. Нийгмийн социал хүрээний харилцаанд аль нь хамаарагдахгүй вэ? /2 оноо/
  - A. Нийгмийн давхраажил
  - B. Нийгмийн бүлгүүдийн харилцаа
  - C. Гэр бүлийн харилцаа
  - D. Төрийн засаглалтай харилцах харилцаа
  - E. Шударга ёс, тэгш байдлын харилцаа
6. Үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээ, амьжиргааны асуудалнийгмийн амьдралын аль хүрээнд хамаарагдах вэ? /1 оноо/
  - A. Социал
  - B. Хүмүүнлэгийн
  - C. Соёл-оюуны
  - D. Эдийн засгийн
  - E. Улс төрийн
7. Хувь хүний нийгэмшлийн анхдагч нэгж нь.....юм. /1 оноо/
  - A. Цэцэрлэг
  - B. Сургууль
  - C. Нийгэм
  - D. Гэр бүл
  - E. Үе тэнгийнхэн
8. Сурагчдын нийгмийн асуудлыг шийдэхэд илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
  - A. Эрүүл мэнд
  - B. Сургалтын боломж нөхцөл
  - C. Сурах хэрэгцээ сонирхол
  - D. Хүний хөгжил
  - E. Улс төрийн үйл ажиллагаа
9. Орчин үеийн нийгмийн хэв маягийн гол шинжийг тэмдэглэнэ үү /2 оноо/
  - A. Суурьшмал газар тариалан, арилжаа худалдаа хөгжих
  - B. Мал, амьтны хүч болон түүхий эд бүтээгдэхүүнийг ашиглах
  - C. Аж үйлдвэр шинжлэх, ухаан техник, технологи эрчимтэй хөгжих
  - D. Мод, чулуу зэргийг хөдөлмөрийн багаж болгон ашиглах
  - E. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнхаараа байх
10. Нийгмийн хэв маягуудтай шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсонбол аль вэ? /3 оноо/
  - A. Агнуурын нийгэм – Технологи – Маш энгийн, мод чулуу зэргийг ашигласан
  - B. Энгийн тариалангийн нийгэм – Суурьшил – Үржил шимтэй газар сэлгэн нүүдэг
  - C. Аж үйлдвэржсэн нийгэм – Эдийн засаг – Илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг
  - D. Газар тариалангийн нийгэм – Тэгш биш байдал – Хүн амын олонх нь баян чинээлэг
  - E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм – Нийгмийн байгууллагууд – Шинжлэх ухаан

11. Монголд нийгмийн ямар хэв маягууд байсан бэ? /1 оноо/  
 А. Аж үйлдвэржсэн В. Аж үйлдвэржсэний дараах С. Иргэний нийгэм  
 D. Уламжлалт буюу нүүдэлчдийн E. Газар тариалангийн
12. Нийгмийн хэв маягийг зэрлэг үе, бүдүүлэг үе, соёлт үе гэж хэн ангилсан бэ? /1 оноо/  
 А. М.Вебер B. Л.Морган C. Г.Ленски D. Д.Белл E. К. Маркс
13. Улс төрийн асуудлын гол шинж юу вэ? /2 оноо/  
 А. Иргэдийг төрийн хэрэгт оролцуулах асуудал  
 B. Нийтийн эрх ашгийг хөндсөн зайлшгүй шийдвэрлэх ёстой асуудал  
 C. Улс төрийн соёлын асуудал  
 D. Улс төрийг танин мэдэх асуудал  
 E. Иргэн хүн нийгэмд байр сууриа эзлэх асуудал
14. “Улс төр бол эрх мэдэлд оролцох түүнийг хуваарилахад нөлөөлөхийн төлөө эрмэлзэн тэмцэх явдал гэж” хэн тодорхойлсон бэ? /1 оноо/  
 А. К.Маркс B. Д. Истон C. М.Вебер D. Аристотель E. Г.Лассуэл
15. Засаглалын хууль ёсны легитим шинжийн эх сурвалж юунд суурилдаг вэ? /2 оноо/  
 А. Захирах, захирагдах зуршил B. Удирдагчийн онцгой авьяас чадвар C. Ёс заншил  
 D. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хэм хэмжээ E. Нэр хүнд
16. Хүч хэрэглэх эрх мэдлийн зохицуулах үүрэгт аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/  
 А. Татвар төлөлт B. Цэргийн дайчилгаа C. Иргэдтэй гэрээ хэлцэл байгуулах  
 D. Ял шийтгэл хүлээлгэх E. Үймээн самуун
17. Төрийн засаглалын онцлог шинжүүдэд аль нь хамааралгүй вэ? /2 оноо/  
 А. Хууль цаазын үндэстэй албадлагын тусгай аппаратад тулгуурлах  
 B. Төрөөс гадна нам, хөдөлгөөний нөлөөлөл хяналтад өртөх  
 C. Улс орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд засаглалын механизмыг өөртөө төвлөрүүлдэх  
 D. Шийдвэр гаргах онцгой эрх эдлэх  
 E. Хүн амыг нийтэд нь хамрах
18. Тоталитар дэглэмийн үндсэн шинж юу вэ? /1 оноо/  
 А. Хүний эрх , эрх чөлөөг дээдлэх B. Иргэдийн улс төрийн оролцоог дэмжих  
 C. Нийгэм, хувь хүний амьдралд хатуу хяналт тогтоох  
 D. Тэгш эрхийн зарчим E. Шударга сонгууль
19. Сонирхлын бүлгийн үүргүүдийг нэрлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/  
 А. Ашиг сонирхлоо нэгтгэх B. Засгийн эрхийн төлөө эрмэлзэх  
 C. Улс төрийн элитийг төлөвшүүлэх D. Ашиг сонирхлоо илэрхийлэх  
 E. Ашиг сонирхлоо мэдээлэх
20. Дэмжлэг ба шаардлага нь улс төрийн системийн ямар сувагт хамаарагдах вэ? /2 оноо/  
 А. Гаралт B. Хувиралт C. Оролт  
 D. Эргэх холбоо E. Дотоод гадаад орчин
21. Сонирхлыг хэрэгжүүлж, шийдвэр гаргадаг улс төрийн системийн гол элементийгнэрлэнэ үү? /1 оноо/  
 А. Улс төрийн нам B. Төр C. Төрийн бус байгууллага  
 D. Сонирхлын бүлэг E. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
22. “Улс төрийн систем бол хүлээн зөвшөөрөгдсөн хууль ёсны албадлагыг хэрэглэхбуюу хэрэглэхийг завдах замаар нэгдэн нягтрах, дасан зохицох чиг үүргийг хэрэгжүүлдэг харилцан хамаарал бүхий үйлдэл юм” гэж хэн тодорхойлсон бэ? /1 оноо/  
 А. Д.Истон B. К. Маркс C. Г.Алмонд D. М. Вебер E. Г. Лассуэл
23. Иргэдийн улс төрийн нийцтэй оролцоог тэмдэглэнэ үү? /2 оноо/

- A. Албан байгууллагад суулт хийх  
C. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглан санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх  
D. Хууль бус ажил хаялтанд оролцох  
E. Авто машины замын хөдөлгөөн хаах
24. Сонгуулийн пропорциональ буюу хувь тэнцүүлэх хувилбарын онцлог юу вэ? /2 оноо/  
A. Иргэд намын төлөө санал өгдөг бөгөөд сонгуулиар улс төрийн намуудын авсан саналын тоотой хувь тэнцүүлэн парламентийн суудлыг намуудад хуваариладаг  
B. Популистууд сонгогдох магадлал өндөр  
C. Нутгийн хүнийг сонгох сэтгэл зүйн хандлага илүү  
D. Санал өгөх, хуваарилах зарчим энгийн ойлгомжтой  
E. Хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцох
25. Удирдлагын шийдвэр иргэн бүрд шуурхай хүрч байх мөн иргэдийн санаа бодол эргээдтөрийн сонорт түргэн хүрч байх зохион байгуулалтын хэлбэрийг юу гэдэг вэ? /1 оноо/  
A. Төлөөллийн ардчилал  
B. Шууд ардчилал  
C. Сонгодог ардчилал  
D. Элитийн ардчилал  
E. Босоо ардчилал
26. Олон ургальч ардчиллын үзэл санааны зарчмуудад аль хамааралгүй вэ? /3 оноо/  
A. Нийгмийн доторх санаа бодлын илэрхийлэл болсон улс төрийн нам, бүлгүүдийн үүргийг чухалчилдаг  
B. Төр засаг нь ард түмнийхээ өмнө биш, харин нам, бүлгийн өмнө хариуцлага хүлээдэг  
C. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд нам, бүлгүүдийг тэгш оролцууланзөвшилцлөөр нийгмийн нэгдмэл байдлыг хангах  
D. Элит нь улс орныг захирдаг аль нэг талаараа шалгарсан давуу талтай хүмүүсээс бүрдэж ерийн олон түмнээс ялгардаг  
E. Шийдвэр гаргахад бүх хүнийг оролцуулах боломжгүй ч ардчиллын зарчмуудыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой
27. Улс төрийн системийг бүтцийнх нь талаас хэрхэн тодорхойлдог вэ? /2 оноо/  
A. Улс төрийн институцуудын нийлбэр цогц  
B. Нийгмийн үнэт зүйлсийг албадлагын замаар хуваарилан байршуулах үйл ажиллагаа  
C. Оролт, гаралт, хувиралт, эргэх холбоо бүхий орчил хөдөлгөөн  
D. Нийгмийн зохион байгуулалтын үндсэн хэлбэр, үйл ажиллагаа  
E. Нийгмийн харилцааг зохион байгуулах тогтолцоо
28. Макро эдийн засгийн үндсэн ойлголтуудад аль нь хамааралгүй вэ? /1 оноо/  
A. Нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүн  
B. Эдийн засгийн өсөлт  
C. Инфляци  
D. Эрэлт, нийлүүлэлт  
E. Гадаад худалдааны тэнцэл
29. Өмч нь эдийн засгийн болоод хууль зүйн ойлголт юм. Доорх өгөгдлөөс аль нь хууль зүйн талыг илэрхийлэх вэ? /2 оноо/  
A. Өмчийн объектийн эдийн засгийн ашиглалт  
B. Өмчийг үр ашигтай хэрэглэх  
C. Өмчийг захиран зарцуулах  
D. Өмчийг арвижуулах  
E. Аж ахуйг удирдах
30. Тухайн барааны үнэ, нийлүүлэлтийн тоо хэмжээ хоёрын шууд хамаарлыг илэрхийлэн харуулдаг хуулийг..... гэнэ. Зөв өгөгдлийг нөхнө үү? /2 оноо/  
A. Эрэлтийн хууль  
B. Нийлүүлэлтийн хууль  
C. Өмчийн харилцаа  
D. Тэнцвэрт үнэ  
E. Эрэлт нийлүүлэлтийн зөрүү
31. Эдийн засгийн тогтолцооны хэв маягуудыг тоочихдоо буруу зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/  
A. Чөлөөт зах зээлийн тогтолцоо  
B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо  
C. Холимог эдийн засгийн тогтолцоо  
D. Нийтлэг эдийн засгийн тогтолцоо  
E. Уламжлалт эдийн засгийн тогтолцоо
32. Төгс бус өрсөлдөөний зах зээлийн төрлүүдийг олж тэмдэглэнэ үү. /3 оноо/

- а. Олигополь                      в. Монопольт өрсөлдөөн                      с. Чөлөөт өрсөлдөөн  
d. Монополь                      e. Борлуулалтын өрсөлдөөн  
A. а, в, d                      B. а, в, с                      C. с, в, а                      D. в, а, с                      E. а, d, e
33. Ажиллах хүчийг бэлтгэх хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үүрэг аль нь вэ? /2 оноо/  
A. Олон хүний амь зуух явдлыг шийдэх боломж хайх  
B. Хөдөлмөрийн албанд ажилгүйдлийн тэтгэвэр авах хүмүүсийг бүртгэх  
C. Ажил эрхлэлтийн түвшинг судлан тогтоох  
D. Нийгмийн эрэлт, захиалагчийн хүсэлтийг үндэслэн шаардлагатай ажил мэргэжлийнхүнийг олох, бэлтгэх, давтан сургах  
E. Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтийн талаар мэдээллийн хэрэгслийг ашиглаж мэдээлэх
34. Бүтцийн ажилгүйдэл нь ажилгүйдлийн ямар хэлбэр вэ? /1 оноо/  
A. Нийгэм эдийн засгийн хөгжлийн дагуу бүтцийн өөрчлөлт гарч түүнийг дагаад шинэсалбар, мэргэжлийн шаардлага өссөнтэй холбоотойгоор үүсдэг ажилгүйдэл  
B. Хүмүүс нэг ажлаас нөгөө ажилд шилжихэд хүлээх хэлбэрээр үүсдэг ажилгүйдэл  
C. Эдийн засгийн уналт, зогсолт, сэргэлт, тогтворжилтийн мөчлөгт заримбүтээгдэхүүний үнэ ханш, инфляцийн өгсөх уруудах хөдөлгөөнтэй холбогдон үүсдэг ажилгүйдэл  
D. Нэг аймаг, бүс нутгаас шилжихтэй холбогдон үүсдэг ажилгүйдэл  
E. Өндөр цалинтай салбарт шилжихийг хүсэж, түүнээ хүлээхтэй холбогдсон ажилгүйдэл
35. Улсын төсөв бүрдүүлдэг татварын бус орлогод доорх өгөдлүүдийн аль нь хамааралгүй вэ? /1 оноо/  
A. Орлогын албан татвар                      B. Нийгмийн даатгалын орлого  
C. Үл хөдлөх эд хөрөнгийн татвар                      D. Нэмэгдсэн өртөгийн татвар                      E. Түрээсийн орлого
36. Өрхийн төсвийн зарлагын талаарх үндсэн өгөгдлийг олж тэмдэглэнэ үү. /1 оноо/  
A. Цалин хөлс                      B. Зээл                      C. Тэтгэвэр, тэтгэмж  
D. Хувийн аж ахуйн орлого                      E. Төлбөрт үйлчилгээ
37. Мөнгөний үндсэн хэлбэрүүдийг тоочихдоо буруу зүйл дурдсан бол аль нь вэ? /1 оноо/  
A. Цаасан мөнгө                      B. Төлбөрийн хэрэгсэл                      C. Зээлийн мөнгө  
D. Тавааран мөнгө                      E. Зоосон мөнгө
38. Улс орны эдийн засгийг санхүүжүүлэх гол үүргийг аль нь хүлээх вэ? /1 оноо/  
A. Сангийн яам                      B. Засгийн газар                      C. Төв банк  
D. Арилжааны банк                      E. Банк бус санхүүгийн байгууллага
39. Тухайн улс орны дотоодод нэг жилд хийгдсэн бүх үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг.....гэнэ. /1 оноо/  
A. Үндэсний орлого                      B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн                      C. Дотоодын нийт бүтээгдэхүүн  
D. Цэвэр бүтээгдэхүүн                      E. Үндэсний нийт бүтээгдэхүүн
40. Далд эдийн засгийн хэлбэрийн жишээг олж тэмдэглэнэ үү. /1 оноо/  
A. Аялал жуулчлалын бизнес эрхлэх                      B. Хувиараа үйлдвэрлэл эрхлэх  
C. Худалдаа, үйлчилгээ эрхлэх                      D. Хууль бус бизнесийн үйл ажиллагаа  
E. Төрийн алба хаших
41. Нийгмийн бүлгүүдийг дээд, дунд, доод гэж ангилах нь нийгмийн давхраажлын аль хэв маягт хамаарах вэ? /1 оноо/  
A. Язгуур                      B. Боолчлол                      C. Анги                      D. Каст                      E. Угсаа гарал
42. Заавал даатгуулах нийгмийн даатгалын хэлбэрт аль нь орохгүй вэ? /1 оноо/  
A. Аж ахуйн нэгж, байгууллага иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч  
B. Төрийн албан хаагч  
C. Байгууллагын болон иргэний малыг тэдэнтэй байгуулсан гэрээгээр маллаж байгаа малчин  
D. Хувиараа хөдөлмөр эрхлэгч эзэд ба иргэд  
E. Төрийн үйлчилгээний ажилтан

43. Нийгмийн даатгалын төрөлд хамаарагдахгүй өгөгдлийг сонгоно уу? /1 оноо/  
А. Тэтгэвэрийн В. Тэтгэмжийн С. Нийгмийн халамжийн  
D. Ажилгүйдлийн E. Эрүүл мэндийн
44. Дондог малчны хүү Бат их сургуулиа амжилттай төгсөөд магистрантурт дэвшин суралцах болов. Батын энэ үйлдэл шилжих хөдөлгөөний ямар ангилалд хамаарагдах вэ? /2 оноо/  
А. Үе доторх В. Үе хоорондын С. Нутаг дэвсгэрийн D. Гэр бүлийн E. Бүтцийн
45. Нийгмийн шилжих хөдөлгөөн мөн чанарын хувьд юунаас үүдэлтэй вэ? /2 оноо/  
А. Эд хөрөнгийн ялгаанаас В. Нийгэм дэх тэгш биш байдлаас С. Хүн амын ядуурлаас  
D. Мэргэжил боловсролоос E. Хувь хүнээс
46. Бие даан амьдарч, өөрөө өөртөө үйлчлэх чадваргүй хүмүүст төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг.....гэнэ. /1 оноо/  
А. Нийгмийн даатгал В. Төсвийн тусламжийн орлого С. Нийгмийн халамж  
D. Төсвийн гадуурх улсын сан E. Ядуурлыг бууруулах сан
47. Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст аль нь хамааралгүй вэ? /1 оноо/  
А. Хөгжлийн бэрхшээлтэй хүн В. Өрх толгойлсон олон хүүхэдтэй эмэгтэй  
С. Ажилгүй хүн D. Малчид E. Бие даан амьдрах чадваргүй ахмад настан
48. Зонхилогч соёлын тодорхойлолт аль нь вэ? /1 оноо/  
А. Нийгмийн бүлэг бүрийн өөрийн гэх үнэлэмж, зан үйлийн дүрмүүдийн цогц  
В. Нийгмийн гишүүдийн олонх нь дагаж мөрддөг үнэлэмж, итгэл үнэмшил, уламжлал, зан заншлын цогц  
С. Ноёлогч үнэлэлэмжүүдтэй зөрчилдөж, түүнийг сөрж байдаг дагуул соёлын хэлбэр  
D. Хүмүүсийн хэрэгцээг хангах зорилгоор бүтээгдсэн оюуны, эд өлгийн үнэт зүйлс  
E. Сүсэг бишрэлийн нийтлэг байдалд тулгуурласан үнэт зүйлс, эрмэлзлэл, зан үйл
49. Нийгмийн цөөнх болох язгууртан дээд давхрааны төлөөлөгчдөд зориулагдан тэдний захиалгаар бий болгосон соёлыг..... гэнэ /1 оноо/  
А. Ардын соёл В. Нийтийн соёл С. Дагуул соёл D. Элитийн соёл E. Сөрөг соёл
50. Төрийн соёлын бодлого гэж юуг хэлэх вэ? /2 оноо/  
А. Нийтийн уран сайхныг хөгжүүлэх төрийн бодлого  
В. Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах бодлого  
С. Үндэсний соёл болон түүнийг бүтээгчдэд хамаарах төрийн бодлого  
D. Үндэсний бичиг үсгийг хөгжлүүлэх төрийн бодлого  
E. Спортын шинэ төрөл хөгжүүлэх төрийн бодлого
51. Дараах өгөгдлөөс аль нь эдийн соёлд хамааралгүй вэ? /1 оноо/  
А. Нум сум В. Анжис С. Байшин барилга D. Ой мод E. Монгол дээл
52. Албан хэм хэмжээнд аль нь хамааралгүй вэ? /1 оноо/  
А. Монгол улсын үндсэн хууль В. Ерөнхийлөгчийн зарлиг С. Ёс заншил, зан үйл  
D. Засгийн газрын тогтоол, шийдвэр E. Засаг даргын захирамж
53. Монгол улс НҮБ-д хэдэн онд элсэн орсон бэ? /1 оноо/  
А. 1946 В. 1948 С. 1955 D. 1956 E. 1961
54. Монгол улсын гадаад бодлогын чиглэлд хамааралгүй зүйлийг тэмдэглэнэ үү. /1 оноо/  
А. Эдийн засгийн В. Соёл-хүмүүнлэгийн С. Улс төрийн  
D. Суртал нэвтрүүлгийн E. Шинжлэх ухаан технологийн
55. Гадаад харилцаа, хамтын үйл ажилгаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дүүрэн дайчлан зохион байгуулах шаардлага манай гадаад бодлогын ямар зарчим бэ? /1 оноо/  
А. Идэвхтэй байх В. Тэнцвэртэй байх С. Үндэсний эрх ашигт нийцсэн байх  
D. Олон тулгуурт байх E. Эрх тэгш байх

56. Монгол улсаас гадаад улстай дипломат харилцаа тогтоох бүрэн эрх аль субъектэд хамаарах вэ?

/1 оноо/

- А. Ерөнхийлөгч  
 В. УИХ  
 С. Засгийн газар  
 D. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл  
 E. Гадаад харилцааны яам

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**

**Санамж: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.**

**2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.**

2.1 Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

а	Нийгмийн хөдөлгөөн	1	Нийгмийн бодит байдлын дэс дараатай өөрчлөлт хөдөлгөөн
в	Нийгмийн үйл явц	2	Нийгэмд болон нийгмийн бүлгүүдэд гарч буй өөрчлөлтийг дэмжих, эсвэл эсэргүүцэх зорилготой хамтын үйлдлүүдийн цогц
с	Нийгмийн ухралт	3	Нийгэмд болон хүний амьдралын нөхцөл, чанар дээшлэх, амьдрах ухаан төгөлдөршихээрэг эерэг үр ашгийн цогц
d	Нийгмийн шинэчлэл	4	Нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан тодорхой цаг хугацаан дахь иж бүрэн суурь өөрчлөлт
e	Нийгмийн дэвшил	5	Нийгэм түүхийн хурдац нь буурах хандлага бүхий сөрөг үр дагавартай хөдөлгөөн

2.2. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

а	Боловсон хүчний нам	1	Намын үндсэн ажлыг цөөн бүлэг хүмүүс, намын лидерүүд эрхэлдэг ба тэд намынхаа бодлогын асуудлыг шийдвэрлэж байдаг
в	Олон түмний нам	2	Хатуу гишүүнчлэлгүй, сонгуулийн үеэр идэвхтэй үйл ажиллагаа явуулах чадамжтай, намын байгууллага нь ихээхэн чөлөөтэй ажиллах боломжтой байдаг
с	Кокус нам	3	Албан ёсны гишүүнчлэлтэй, шаталсан зохион байгуулалтын бүтэцтэй, сонгуулийн бус үед ч идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, гишүүд нь намынхаа ажилд байнга оролцох учиртай
d	Зүүний нам	4	Төрийн нийгмийн бодлогыг хязгаарлах чиглэлтэй хувийн өмчтөн, бизнес эрхлэгчид дунд ангийн эрх ашгийг хамгаалдаг
e	Барууны нам	5	Төрийн нийгмийн бодлого явуулах чиглэлтэй, ядуу хэсгийн эрх ашиг, бүх нийтийн тэгшгэх ёсыг хамгаалдаг

2.3. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

а	Картель	1	Бүтээгдэхүүнээ хамтран борлуулах ажлыг зохион байгуулах зорилготой монопольт нэгдэл
в	Синдикат	2	Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний ноогдол хэмжээ болон борлуулах зах зээлээ хуваах тухай монопольт хэлэлцээр
с	Трест	3	Санхүүгийн нэгдмэл төвтэй үйлдвэрийн газруудын олон салбаруудын тогтолцоо
d	Концерн	4	Хамтын өмч, бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба борлуулалтын ерөнхий удирдлагын дор нэгдсэн монопольт нэгдэл
e	Корпораци	5	Бие даасан аж ахуйн нэгжүүдийн хувь оруулсан өмч бүхий томоохон аж ахуй

2.4 Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?

/5 оноо/

а	Соёл	1	Зонхилогч соёлоос ялгарч ноёлогч үнэлэмжүүдтэй зөрчилдөж байдаг соёл
в	Нийтийн соёл	2	Тухайн улс орон дахь ард олны нийтлэг итгэл, үнэмшил, загвар хэм хэмжээг тодорхойлж байдаг
с	Ардын соёл	3	Нийгмийн цөөнх буюу дээд хэсгийнхний захиалгаар мэргэжлийн хүмүүс бий болгосон соёл
d	Элитийн соёл	4	Нийгмийн бүхий л давхаргад хүртээмжтэй болсон соёл
e	Сөрөг соёл	5	Хүний бүтээсэн болон бүтээж байгаа, хүн өөрийгөө хүн болгон төлөвшүүлэх эд өлгийн болон оюуны үнэт зүйлсийн цогцолбор

